



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/147/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Утас: 70523020

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДГА	Дорноговь аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.25 № 1-6/159

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ
ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ГАНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 18-аас 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Шүүхийн Тамгын газар нь шударга шүүхээр шүүлгэх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Шүүхийн тамгын газар захиргааны удирдлагын дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;
- шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;
- хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд

байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр -ын хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны 489,739.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,897.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	100.00	Томилолтын зам хоногийг илүү олгосон.
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	100.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Илрүүлэлт. Зардлын данстай холбоотой асуудал.

Албан томилолтыг бодож олгохдоо зам хоног буюу томилолтоор ажилласан хоногийг илүү тооцсон.

Энэ нь Сангийн сайдын 1992 оны 30 дугаар тушаалаар батлагдсан “Албан томилолтын зардал олгох заавар”-ын 8 дахь заалттай нийцэхгүй байна.

Эрсдэл. Тооцоолол буруу хийгдэж илүү олгогдох.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан 2018 онд 489,739.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 489,205.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын 9 дүгээр шүүх Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,157,765.25	27,534,657.50
33	АВЛАГА	00.00	134,606.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	134,606.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,157,765.25	27,400,051.50
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	19,157,765.25	27,400,051.50
35410	Бичиг хэргийн материал	1,421,690.00	6,087,086.00
35420	Аж ахуйн материал	17,621,075.25	20,442,965.50
35440	Түлш, шатах тослох материал	115,000.00	870,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	262,320,313.40	576,387,845.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	262,320,313.40	576,387,845.11
392	Биет хөрөнгө	262,251,563.52	561,387,845.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	317,954,200.00	520,774,830.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	00.00
		111,623,173.72	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,517,151.00	61,517,151.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,517,151.00	-61,517,151.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,093,702.01	118,583,217.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,058,391.92	-
			102,394,209.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,376,400.70	49,912,748.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,491,173.55	-28,824,417.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000.00	1,812,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,000.00	00.00
39217	Ном	00.00	1,522,976.00
393	Биет бус хөрөнгө	68,749.88	15,000,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-756,250.12	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	15,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	281,478,078.65	603,922,502.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	281,478,078.65	603,922,502.61
51	Засгийн газрын хувь оролцоо	281,478,078.65	603,922,502.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	149,647,239.77	164,647,239.77
51101	Өмч: - төрийн	149,647,239.77	164,647,239.77
512	Хуримтлагдсан үр дүн	-17,181,461.04	-12,856,928.36
51210	Өмнөх үеийн үр дүн	-17,181,461.04	-17,181,461.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,324,532.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	149,012,299.92	452,132,191.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	281,478,078.65	603,922,502.61

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,221,607.80	514,686,336.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,054,607.80	24,812,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,054,607.80	24,812,730.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,054,607.80	24,812,730.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,054,607.80	24,812,730.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,167,000.00	489,873,606.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	418,297,000.00	489,739,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	418,297,000.00	489,739,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,870,000.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,870,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	134,606.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	134,606.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	448,416,298.72	505,991,540.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,416,298.72	505,991,540.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,416,298.72	505,458,399.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,540,656.00	342,635,213.00
210101	Үндсэн цалин	222,785,656.00	271,774,266.00
210102	Нэмэгдэл	00.00	46,747,947.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,755,000.00	15,837,000.00
210104	Урамшуулал	00.00	8,276,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,892,113.00	41,116,200.00
210201	Тэтгэврийн даатгал	16,476,802.00	28,056,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,353,830.00	3,265,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,883,062.00	2,612,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	520,436.00	653,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,657,983.00	6,530,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,954,822.00	34,845,531.00
210301	Гэрэл, цахилгаан	3,669,386.00	5,375,889.00
210302	Түлш, халаалт	14,060,200.00	26,842,199.00
210303	Цэвэр, бохир ус	2,225,236.00	2,627,443.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,528,466.50	28,038,048.75
210401	Бичиг хэрэг	5,917,177.50	7,331,804.00
210402	Тээвэр, шатахуун	5,533,700.00	10,372,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,900,279.00	6,981,056.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,177,310.00	2,880,988.75
210408	Бараа материал акталсны зардал	00.00	472,000.00
2105	Нормативт зардал	878,575.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	878,575.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,817,461.00	11,473,535.00
210604	Урсгал засвар	118,817,461.00	11,473,535.00
2107	Томилолт, зочны зардал	3,628,350.00	7,395,200.00
210702	Дотоод албан томилолт	3,628,350.00	7,395,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,002,820.00	6,039,559.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	802,100.00	4,651,949.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	670,720.00	839,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	00.00	17,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,173,035.22	33,415,112.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,700.00	3,952,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,112,335.22	29,462,162.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	533,141.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	533,141.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	533,141.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,194,690.92	8,694,795.28
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,661,375.99	4,370,262.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,661,375.99	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	4,370,262.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,661,375.99	-4,370,262.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-19,856,066.91</u>	<u>4,324,532.68</u>

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	557,668,500.00	495,191,755.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	557,668,500.00	495,191,755.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	549,798,500.00	489,739,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	549,798,500.00	489,739,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,870,000.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,870,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	5,452,755.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	5,452,755.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	557,668,500.00	490,961,955.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,668,500.00	490,961,955.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,463,148.00	484,976,059.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,138,904.00	342,635,212.00
210101	Үндсэн цалин	298,843,804.00	271,774,365.00
210102	Нэмэгдэл	00.00	46,747,847.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,277,000.00	15,837,000.00
210104	Урамшуулал	9,018,100.00	8,276,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,470,090.00	41,116,200.00
210201	Тэтгэврийн даатгал	23,208,212.00	28,056,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,315,445.00	3,265,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,652,355.00	2,612,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	663,088.00	653,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,630,990.00	6,530,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,070,576.00	34,845,531.00
210301	Гэрэл, цахилгаан	5,820,499.00	5,375,889.00
210302	Түлш, халаалт	25,564,000.00	26,842,199.00
210303	Цэвэр, бохир ус	2,686,077.00	2,627,443.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,111,058.00	32,946,106.00
210401	Бичиг хэрэг	7,483,375.00	10,616,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,317,400.00	11,127,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,732,629.00	6,981,056.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,577,654.00	4,221,650.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,870,000.00	13,270,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	1,270,200.00
210604	Урсгал засвар	118,870,000.00	12,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,896,800.00	7,395,200.00
210702	Дотоод албан томилолт	5,896,800.00	7,395,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,105,720.00	6,267,610.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,880,000.00	4,880,000.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	670,720.00	839,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	25,000.00	17,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,205,352.00	5,985,896.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,700,000.00	5,452,755.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	5,452,755.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,700,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,352.00	533,141.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,352.00	533,141.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>4,229,800.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,229,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,229,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,229,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,229,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-4,229,800.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	149,647,239.77	149,012,299.92	-17,181,461.04	281,478,078.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	149,647,239.77	149,012,299.92	-17,181,461.04	281,478,078.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	303,119,891.28	00.00	303,119,891.28
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	15,000,000.00	00.00	4,324,532.68	19,324,532.68
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,647,239.77	452,132,191.20	-12,856,928.36	603,922,502.61

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТГ

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,635,400.00	342,635,212.00	188.00
210101	Үндсэн цалин	275,767,400.00	271,774,365.00	3,993,035.00
210102	Нэмэгдэл	43,228,000.00	46,747,847.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,364,000.00	15,837,000.00	-473,000.00
210104	Урамшуулал	8,276,000.00	8,276,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,116,200.00	41,116,200.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	28,056,100.00	28,056,100.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,265,000.00	3,265,000.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,612,000.00	2,612,000.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	653,000.00	653,000.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,530,100.00	6,530,100.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,249,700.00	34,845,531.00	404,169.00
210301	Гэрэл, цахилгаан	5,448,200.00	5,375,889.00	72,311.00
210302	Түлш, халаалт	26,821,400.00	26,842,199.00	-20,799.00
210303	Цэвэр, бохир ус	2,980,100.00	2,627,443.00	352,657.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,457,500.00	33,446,106.00	11,394.00
210401	Бичиг хэрэг	10,616,200.00	10,616,200.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	11,127,200.00	11,127,200.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,214,100.00	6,981,056.00	1,233,044.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	4,221,650.00	-
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	17,000,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	12,000,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	7,395,200.00	7,395,200.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,395,200.00	7,395,200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,385,000.00	6,267,610.00	117,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,880,000.00	4,880,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	950,000.00	839,850.00	110,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	0.00
210807	Газрын төлбөр	25,000.00	17,760.00	7,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6000000.00	6000000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	6,000,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	489,739,000.00	489,205,859.00	533,141.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	02.00	02.00	0.00
610001	Төсвийн байгууллага	02.00	02.00	0.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	00.00	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	00.00	00.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	23.00	-1.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00	0.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	04.00	04.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	10.00	-1.00